



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 323

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 6,000,000.00 /зургаан сая/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар, Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газрын дарга Д.Даваасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөллөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн
 223 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Шүүхийн тамгын газруудын нэр	Автомашинны нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Ховд аймаг дахь Шүүхийн тамгын газар	Тоёото Королла 57-51 ХОА	NZE1243006065	2001/2008	270,650	6,000,000.00	1,000,000.00
Нийт дүн						6,000,000.00	1,000,000.00
						/зургаан сая/	/нэг сая/